

..... оны ..... сарын ..... өдрийн Хоршооны бүх гишүүдийн хурлын .... тоот тогтоолоор батлав.

### ХОРШООНЫ ГИШҮҮДЭД НООГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ, ОЛГОХ ЖУРАМ

Хоршооны хөрөнгө нь бүхэлдээ гишүүдийн хувь нийлүүлсэн болон бусад хөрөнгөөс бүрддэг. Энэхүү хөрөнгө дээр тулгуурлан үйл ажиллагаа явуулснаар олсон ашиг орлого нь хоршооны гишүүдийнх бөгөөд түүнийг хэрхэн хуваарилж зарцуулах нь тэдний эрх мэдлийн асуудал бөлгөө. Үүнтэй холбоотойгоор үйл ажиллагааны ашиг орлогоо гишүүддээ хэрхэн хуваарилах, олгох, зарцуулах асуудлыг энэхүү журмаар зохицуулна.


Хоршоо нь тухайн жилийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон үлдэх орлого (татвар төлсний дараах үлдэх орлого) буюу цэвэр ашгийг бүрэн хэмжээгээр гишүүдэд хуваарилах ба энэ үед гишүүдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хоршооны үйлчилгээ авсан байдал, хоршооны үйл ажиллагаанд оролцсон байдлыг харгалзана. Ноогдол ашгийн түвшинг тогтоохдоо дараах хувь хэмжээг баримтална. Үүнд:

Дү	Харгалзах үзүүлэлт	Хуваарилах хэмжээ	
		Хувь	Бодит дүн-төгрөг
1	Хувь нийлүүлсэн хөрөнгө	...	...
2	Хоршооны үйлчилгээ авсан байдал	...	...
3	Үйл ажиллагаанд оролцсон байдал	...	...
<b>Д Ү Н</b>		<b>100.0</b>	...

Дээрх харгалзах үзүүлэлт бүрд ногдох хэмжээг тодорхойлсны дараа гишүүн нэг бүрт хуваарилах ноогдол ашгийн хэмжээг харгалзах үзүүлэлт нэгбүрээр тодорхойлон тооцно. Тодорхойлон тооцохдоо дараах загвар хүснэгтийг ашиглана.

Дү	Гишүүний нэр	Харгалзах үзүүлэлтүүдэд ногдох ашиг			Нийт хуваарилах ноогдол ашиг
		Хувь нийлүүлсэн хөрөнгө	Хоршооны үйлчилгээ авсан байдал	Үйл ажиллагаанд оролцсон байдал	
1					
2					

Гишүүдэд хуваарилах ноогдол ашгийн хэмжээг тодорхойлсны дараа хуваарилсан ноогдол ашгаас гишүүдэд гар дээр нь тавьж олгох дүнг тооцож гаргана. Гэхдээ хөрөнгийн хүрэлцээний хувьд бололцоотой түвшинд хүрсэн үед хуваарилсан ашгийг гишүүдэд бүрэн



хэмжээгээр тавьж олгоно. Харин хөрөнгийн боломж хүрэлцээгүй үед хоршооны хуваарилсан ашгаас гишүүдэд тавьж олгох хэмжээг тодорхойлон нэмэлт тооцоолол хийнэ. Гишүүдэд хуваарилан тавьж олгох ашиг орлогын хэмжээг тодорхойлохдоо хоршооны хөрөнгийн чадавхийн байдал, гишүүдийн хэрэгцээ, ашиг сонирхлыг харгалзан үзнэ. Гишүүдэд хуваарилан тавьж олгох ашиг орлогын түвшингийн байдлыг харгалзан тэргүүлэгчид энэ талаар санал бэлтгэн гишүүдэд урьдчилан танилцуулах ба бүх гишүүдийн хурлаар хэлэлцүүлж баталгаажуулсан байна. Ашгаас хоршооны сангуудад үлдээх болон гишүүдэд тавьж олгох хэмжээг тодорхойлохдоо дээрх график-бүдүүвчид харуулсан зарчмыг баримтална.

Хуваарилсан ноогдол ашгаас хоршоонд гишүүнд тавьж олгох хэмжээ, дүнг дараах байдлаар тодорхойлно.

Д/д	Гишүүний нэр	Хуваарилсан нийт ноогдол ашиг төгрөгөөр	Гишүүний хоршоонд үлдээсэн ноогдол ашиг буюу ХНХ-өө нэмэгдүүлсэн дүн төгрөгөөр	Гишүүнд тавьж олгосон ноогдол ашиг төгрөгөөр	Зөвшөөрч, хүлээн авсан гишүүний гарын үсэг
1					
2					

Хоршооны гишүүн нь хуваарилсан ноогдол ашгийг бүрэн хэмжээгээр болон хэсэгчлэн хоршооноос авалгүйгээр үлдээж хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлж болно. Мөн тавьж олгохоор хуваарилсан ноогдол ашгийн зохих хувийг хувь нийлүүлсэн хөрөнгөдөө нэмж оруулах боломжтой.

Хоршоо нь жил бүрийн ноогдол ашгийг хуваарилах, олгох ажлыг тухайн санхүүгийн жил дууссанаас хойш 3 сарын дотор багтаан гүйцэтгэнэ. Ноогдол ашгийг мөнгөн болон эд материалын хэлбэрээр олгож болно.

Хоршоо нь гишүүдийн идэвх, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор бүх гишүүдийн хурлыг хүндэтгэх шалтгаангүйгээр 3 ба түүнээс дээш удаа тасалсан, хоршоонд бүтээгдэхүүн нийлүүлэх үүргээ 3 ба түүнээс дээш удаа зөрчсөн тохиолдолд ноогдол ашиг хуваарилахгүй байж болно.

Журмын биелэлтэнд хоршооны хяналтын зөвлөл хяналт тавьж, тайлангийн жилийн эцэст шалгалт хийж үр дүнг бүх гишүүдийн болон төлөөлөгчдийн хуралд тайлагнахын зэрэгцээ мэдээлэх хуудас гаргаж байна